



МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД

15170 Улаанбаатар хот, Чингэлтэр дүүрэг, 1 дүгээр хороо,
Барилга-дүн талбай 3, Засгийн газрын XII байр
Утас: 33 06 72 / 600 3333 1126 / Факс: 376-111 32 29 04
И-мэйл: info@bar.gov.mn / Бүбсэйг: www.mcsud.gov.mn

2022.04.20 № 1/1870

Танан ... ны № ... -1

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ,
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ДАРГА,
ЗАХИРАЛ НАРТ

Жишиг материал хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 88 дугаар тогтоолын 4, 5 дахь заалтыг хэрэгжүүлэхээр Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 08 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн өөрчлөлтийг тооцож, магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Барилга байгууламжийн төсөвт өртгийн өөрчлөлтийг тооцохын тулд Ажлын хэсэг барилгын материалын үнийн өөрчлөлтийг тооцоход ашиглах барилгын 20 бүлгийн 539 нэр төрлийн материалын үнийн судалгааг гаргаж баталсан бөгөөд "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих барилга байгууламжийн төсөвт өртгийн /барилгын материалын үнэ/ өөрчлөлтийг тооцох түр журам"-ыг Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 75 дугаар тушаалаар батлуулаад мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус Ажлын хэсэг нь Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолд заасны дагуу зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг хамруулан ажиллаж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэр (гадаадын зээл, тусламж, сангийн хөрөнгө, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт)-ээр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд дээрх журамд заасан зарчмыг баримтлан, үнийн өөрчлөлтийг тооцох барилгын материалын үнийг Ажлын хэсгээс нарийвчлан гаргаж, харьцуулалт хийж /20 бүлгийн 539 нэр төрлийн материал/ баталсан жагсаалтыг харгалзан төсөвт өртгийн өөрчлөлтийг тооцох нь төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжтой тул дээр дурдсан холбогдох материалыг жишиг болгон хэрэглүүлэхээр хүргүүлэв.

Хавсралт ... хуудастай.

Б.МӨНХБААТАР